



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 281

Мандалговь


Хөрөнгө бэлтгэж бүртгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. “Дундговь-Ус”ОНӨҮГ-т хавсралтын дагуу БХБЯ-ны хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 56'000'000 /тавин зургаан сая/ төгрөгийн ус зөөврийн машин болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 46'947'216 /дөчин зургаан сая есөн зуун дөчин долоон мянга хоёр зуун арван зургаа/ төгрөгийн Айраг, Мандал багийн цэвэр усны шугамыг данс бүртгэлдээ бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг “Дундговь-Ус” ОНӨҮГазрын дарга Р.Энхмаад даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 12 сарын
12 өдрийн ... -р тогтоолын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
БХБЯ-ны хөрөнгө оруулалтаар ирсэн				
1	Ус зөөврийн машин	1 ш	56 000 000	56 000 000
	Нийт дүн	1	56 000 000	
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр				
1	Мандал, Айраг багийн цэвэр усны шугам	1,8 км	46 947 216	46 947 216
	Нийт дүн	1,8 км	46 947 216	
	Бүгд дүн			102 947 216